



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны бүтэц,
орон тоо, нэгжүүдийн чиг үүргийг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны бүтцийн нэгжүүдийг дараах байдлаар тогтоосугай:

Нэг. Зах зээлийн хөгжлийн газар:

- 1.1. Зах зээлийн судалгаа, шинжилгээний хэлтэс;
- 1.2. Зах зээлийн нэгдсэн мэдээллийн хэлтэс;
- 1.3. Зах зээлийн хөгжлийг дэмжих хэлтэс.

Хоёр. Эрсдэлийн удирдлага, зохицуулалтын газар:

- 2.1. Бодлого зохицуулалтын хэлтэс;
- 2.2. Эрсдэлийн удирдлагын хэлтэс.

Гурав. Үнэт цаасны зохицуулалтын газар:

- 3.1. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын хэлтэс;
- 3.2. Санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн хэлтэс;
- 3.3. Мэргэжлийн оролцогчдын хэлтэс.

Дөрөв. Даатгалын зохицуулалтын газар:

- 4.1. Даатгалын зах зээлийн зохицуулалтын хэлтэс;
- 4.2. Даатгалын бүтээгдэхүүн, хөгжлийн хэлтэс.

Тав. Бичил санхүүгийн зохицуулалтын газар:

- 5.1. Бичил санхүүгийн зохицуулалтын хэлтэс;
- 5.2. Бичил санхүүгийн бүтээгдэхүүн, хөгжлийн хэлтэс.

000066

Зургаа. Хяналт шалгалтын газар:

- 6.1. Үнэт цаасны хяналтын хэлтэс;
- 6.2. Даатгалын хяналтын хэлтэс;
- 6.3. Бичил санхүүгийн хяналтын хэлтэс;
- 6.4. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хэлтэс.

Долоо. Үйл ажиллагааны газар:

- 7.1. Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтэс;
- 7.2. Эрх зүйн хэлтэс;
- 7.3. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс;
- 7.4. Мэдээлэл, технологийн хэлтэс;
- 7.5. Сургалт, сурталчилгааны хэлтэс;

Найм. Зах зээлийн үйлчилгээний хэлтэс.

Ес. Дотоод аудитын хэлтэс.

2. Ажлын албаны бүтцийг хүний орон тоотойгоор баталж, бүтэц, зохион байгуулалт /матриц/-ыг нэгдүгээр хавсралтаар, нэгжүүдийн ажлын чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 172 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолоор батлагдсаны дагуу Ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн зохион байгуулж, тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Ажлын алба/Ц.Энхбаяр/-нд үүрэг болгосугай

ДАРГА




3.НАРАНТУЯА

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн ... дугаар тогтоолын нэгдүгээр хэсгээр

Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц, зохион байгуулалт (матриц)


- Санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах
- Ил тод, шударга хүргэмжтэй - санхүүгийн зах зээлийн хөгжил
- Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах



НЭГДМЭЛ УДИРЛАГА

ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ УДИРЛАГА

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЖЛЫН
АЛБА ТҮҮНИЙ НЭГЖҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ**



НЭГ. АЖЛЫН АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ:

- 1.1. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээл дэх мэргэжлийн оролцогчдын төлбөрийн чадварыг бэхжүүлэх талаар Хорооноос тогтоосон шаардлагыг мөрдүүлэх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон заавар, зөвлөмжийн төсөл боловсруулж Хороонд оруулах;
- 1.2. Санхүүгийн зах зээл дэх мэргэжлийн оролцогчдын нягтлан бодох бүртгэл, тайлангийн маягт, тайлагнах журмын төслийг боловсруулж хэрэгжилтэд нь хяналт тавих;
- 1.3. Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, даатгуулагч, хадгаламж эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээ авахад нь Хороонд дэмжлэг үзүүлэх;
- 1.4. Санхүүгийн зах зээлийн хөгжлийн талаарх мэдээлэл судалгааны сан бүрдүүлэх;
- 1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд мониторинг хийх;
- 1.6. Хорооноос олгосон зөвшөөрөл, эрх болон тэдгээрт оруулсан өөрчлөлтийг бүртгэх, үнэт цаасны нэгдсэн бүртгэл хөтлөх;
- 1.7. Хууль тогтоомж, журам, заавар, стандарт, арга зүйн материал зөвлөмжийг сурталчилах ажлыг зохион байгуулах;
- 1.8. Олон нийтийг Хорооны болон санхүүгийн зах зээл дэх мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах, лавлагаа өгөх;
- 1.9. Хорооноос санхүүгийн зах зээл дэх мэргэжлийн оролцогчид хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих болон Хороо, Хяналтын зөвлөл, түүний гишүүдэд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь техник, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- 1.10. Хорооноос санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хөгжлийн асуудлаар гадаад орон болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- 1.11. Хорооноос санхүүгийн зах зээл дэх мэргэжлийн оролцогчдын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх.

ХОЁР. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Зах зээлийн хөгжлийн газар нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, ил тод, шударга, хүртээмжтэй санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилтын хүрээнд санхүү /банк, бичил санхүү/, даатгал, хөрөнгийн зах зээлийн талаарх нэгдсэн мэдээллийг цуглуулж, боловсруулан анализ, дүгнэлт хийж Хорооны удирдлага, ажилтнууд, эрх бүхий байгууллага болон зах зээлд оролцогчдыг үнэн зөв мэдээллээр хангах, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих чиглэлээр төрийн бусад байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах үндсэн үүрэгтэйгээр дотроо Зах зээлийн судалгаа, шинжилгээний хэлтэс, Зах зээлийн мэдээллийн нэгдсэн төв /хэлтэс/, Зах зээлийн хөгжлийг дэмжих хэлтэс гэсэн бүтэцтэйгээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1. Зах зээлийн судалгаа, шинжилгээний чиглэлээр:

- 2.1.1. Санхүүгийн зах зээлд нөлөөлж буй макроэдийн эдийн засгийн хүчин зүйлд судлагаа, шинжилгээг хийх;
- 2.1.2. Олон улсын байгууллагуудын судалгааны мэдээллүүдийг төвлөрүүлэх, боловсруулах, ашиглах.;
- 2.1.3. Олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар харьцуулсан судалгаа хийх;
- 2.1.4. Зах зээлийн нэгдсэн мэдээллийн хэлтсээс нэгтгэгдсэн тайланд судалгаа, шинжилгээний үндсэн дээр дүгнэлт хийн зах зээлийн талаарх нэгдсэн мэдээллийг бэлтгэн удирдлага, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд хүргүүлэх;
- 2.1.5. Хорооны бусад газар, хэлтэсүүдээс тухайн хариуцсан салбартаа хийх судалгаа, шинжилгээний ажилд шаардлагатай арга зүйн зөвлөгөө өгөх, тодорхой мэдээллээр хангах;
Судалгаа, шинжилгээнд шаардлагатай тоон мэдээллийн сан бүрдүүлэхэд санал өгөх.

2.2. Зах зээлийн нэгдсэн мэдээллийн чиглэлээр:

- 2.2.1. Санхүү, үнэт цаасны зах зээлийн системийн нэгдсэн мэдээ, тайлан тэнцэл, мэдээллийг нэгтгэн боловсруулж, олон нийтийг үнэн зөв мэдээллээр тогтмол хангаж байх;
- 2.2.2. Санхүүгийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээлэлд орсон өөрчлөлт, шинэчлэлтийг баяжуулж, боловсруулалт хийж байх;
- 2.2.3. Газар, хэлтэс, нэгж тус бүрт хууль журмын дагуу ирүүлж байгаа зохицуулалттай этгээдийн тайлан мэдээ, бүртгэгдсэн үнэт цаас, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн бүртгэлийн хяналт шалгалтын тайлан, мэдээ, мониторингийн дүн мэдээ зэрэг тоон үзүүлэлтээр илэрхийлж болох бүхий л мэдээллийг холбогдох нэгжээс нэгтгэсэн байдлаар хүлээн авч, мэдээллийн санд оруулах;
- 2.2.4. Удирдлагын мэдээллийн тогтолцоог бий болгож, түүнд хамаарах мэдээ, тайланг боловсруулан хорооны удирдлагыг цаг тухайд нь мэдээллээр хангаж байх;
- 2.2.5. Монголбанкны Зээлийн мэдээллийн сангаас холбогдох мэдээллийг авч Ажлын албаны нэгжүүдийг холбогдох мэдээллээр хангах;
- 2.2.6. Эдийн засгийн макро түвшний тоон үзүүлэлтүүд үнэн зөв, улсын хэмжээнд хоорондоо харилцан уялдаа бүхий байх шаардлагыг хангаж, мэдээлэл, судалгаа, статистикийн мэдээлэл хариуцсан бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, харилцан мэдээллээ солилцон ажиллах.

2.3. Зах зээлийн хөгжлийг дэмжих чиглэлээр:

- 2.3.1. Гадаад, дотоодын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдалд дүгнэлт хийх, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар таамаглал дэвшүүлэх, хөгжлийн загварчлал боловсруулах;
- 2.3.2. Санхүүгийн зах зээлийг зохистой бүтэц бүхий ил тод, шударга өрсөлдөөнтэй, хүртээмжтэй зах зээл болгон хөгжүүлэхэд чиглэсэн дэд бүтцийн уялдаа холбоог сайжруулахад шаардлагатай зохицуулалтыг хийх, санал, зөвлөмж, чиглэлийг бусад газар хэлтсүүдэд хүргүүлэх;
- 2.3.3. Зах зээлийн хөгжлийг дэмжсэн олон улсын байгууллага болон гадаад орнуудаас туслалцаа, дэмжлэг авах, төсөл хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 2.3.4. Хувьцаа, бондын захыг хөгжүүлэх ажлыг идэвхижүүлж, энэ чиглэлээр төрийн бусад байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 2.3.5. Үндэсний болон биржэд бүртгэлтэй компаниудын засаглалыг хөгжүүлэх, санхүү, төлбөрийн чадварыг нь сайжруулахыг эдийн засгийн аргаар дэмжих, улмаар хөрөнгийн зах зээлд идэвхитэй үйл ажиллагаа бүхий оролцогч болгох нөхцлийг бүрдүүлэх;

2.3.6. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл болон Төлбөр тооцооны үндэсний зөвлөлөөр дамжуулан төрийн бусад байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, төлбөр тооцооны системийг боловсронгуй болгох;

2.3.7. Зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр холбогдох судалгааг хийж, нэвтрүүлэх чиглэлээр холбогдох газар, хэлтсүүдэд чиглэл өгөх;

2.3.8. Хөрөнгө оруулалтын менежментийн тогтолцоог чадавхижуулах;

2.3.9. Биржийн бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх.

2.3.10. Хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хөтөлбөрийн нэгдсэн үнэлгээ гаргах;

2.3.11. Мэргэшлийн зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах.

ГУРАВ. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Санхүүгийн зах зээлийн эрсдэлийн түвшинг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, эрсдэлийн хүчин зүйлд судалгаа шинжилгээ хийх, эрсдэлээс сэргийлэх, бууруулах арга хэмжээний санал, төлөвлөгөө, эрсдэлийг удирдах талаар баримтлах ерөнхий чиг, нэгдсэн бодлогыг боловсруулж, санхүүгийн зах зээлийн эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоог бий болгон, зах зээлийн оролцогч тус бүрийн дагаж мөрдөх стандарт, дүрэм, зохицуулалтын эрх зүйн акт, зохистой харьцааны хэм хэмжээг тогтоож санхүүгийн системийн найдвартай, тогтвортой ажиллагааг хангах үндсэн үүрэгтэйгээр дотроо Эрсдэлийн удирдлагын хэлтэс, Бодлого, зохицуулалтын хэлтэс гэсэн бүтэцтэйгээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1. Бодлого зохицуулалтын чиглэлээр:

3.1.1. Хорооны нэгжүүдтэй тухайн салбарын зохицуулалтын хууль, эрх зүйн актыг боловсруулахад бодлогын түвшинд хамтран ажиллах, салбар бүрийн зохицуулалтын нэгжээс боловсруулсан бодлого, эрх зүйн акт, журам зааврын уялдаа холбоог хангах, сайжруулах, бодлогын нэгдсэн удирдлагаар хангах;

3.1.2. Олон улсад дагаж мөрдөгдөж байгаа стандарт, туршлагыг өөрийн орны онцлог шинж байдалтай уялдуулан санхүүгийн зах зээлийн дагаж мөрдөх зохицуулалтын стандарт, санхүүгийн үйлчилгээ, зах зээлийн арилжааг тэгш, шударга эрхлэн явуулах зарчим, дүрэм, зохистой харьцааны хэм хэмжээ, заавар журмыг тухайн салбарын зохицуулалтын нэгжтэй хамтран боловсруулж, батлуулах;

3.1.3. Санхүүгийн зах зээлийн хяналт шалгалттай холбоотой заавар, журмыг боловсронгуй болгох, шинэчлэн найруулах, хяналт шалгалт хариуцсан нэгжтэй эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгох чиглэлээр хамтран ажиллаж, холбогдох хууль эрх зүйн актуудыг боловсруулж батлуулах;

3.1.4. УИХ, Засгийн газраар хэлэлцэн шийдвэрлэх бодлогын баримт бичиг, хууль эрх зүйн актын төсөл, төрийн байгууллагууд, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөг боловсруулах, санал дүгнэлт өгөх, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээ авах.

3.2. Эрсдэлийн удирдлагын чиглэлээр:

3.2.1. Санхүүгийн зах зээлийн эрсдэлийн түвшинг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг тогтоох, эрсдэлийн хүчин зүйлд судалгаа шинжилгээ хийх, эрсдэлийг удирдах талаар баримтлах бодлогыг боловсруулж, эрсдэлийн зохистой удирдлагын тогтолцоог бий болгох,

3.2.2. Санхүүгийн зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хэрэглэх мэдээллийн системийг бий болгох, эрсдэлийн удирдлагатай холбоотой олон улсын туршлагыг судлах, өөрийн

орны онцлог шинж байдалтай уялдуулан нэвтрүүлэх, эрсдэлийн зохистой удирдлагын талаар хууль эрх зүйн акт, заавар журам, зааварчилгаа, зөвлөмж боловсруулах,

3.2.3. Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн түвшинг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг тогтоох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний санал, төлөвлөгөө гаргах, үйл ажиллагааны эрсдэлийн зохистой тогтолцоог бий болгох.

3.2.4. Зах зээлийн шударга өрсөлдөөний байдал, хадгаламж, хуримтлал, хөрөнгө оруулалтыг хамгаалах хамгаалалтын тогтолцоо, санхүүгийн тогтворжилтын сан, батлан даалт, хадгаламжийн даатгал, эрсдэлийн сан зэрэг системийн эрсдэлээс хамгаалах тогтолцооны талаар судалгаа хийж, боловсронгуй болгох шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Үнэт цаасны зах зээлийн харилцааг ил тод, үр ашигтай, шударга өрсөлдөөнтэй байх нөхцөлийг бүрдүүлж, мэдээллийн нээлттэй байдлыг хангуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, зохицуулалттай этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг, шаардлага, шалгуурыг хангуулж, зах зээлийн тогтвортой дэд бүтцийг бүрдүүлэх, өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэж, хуульд заасны дагуу хамтран ажиллах, нийтэд санал болгох үнэт цаас, үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргахыг зөвшөөрөх, бүртгэх, үнэт цаас гаргах, хувьцаа худалдан авах болон Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцаанд хуулиар тавьсан шалгуур, шаардлагыг хангуулах үндсэн үүрэг бүхий Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын хэлтэс, Санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн хэлтэс, Мэргэжлийн оролцогчдын хэлтэс гэсэн бүтэцтэйгээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын чиглэлээр:

4.1.1. Үнэт цаасны зах зээлийн ерөнхий зохицуулалтыг сайжруулах чиглэлээр санал боловсруулах, зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрмийг баталж, мөрдүүлэх, боловсронгуй болгох, олон улсын үнэт цаасны хороодын гаргасан заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.1.2. Зах зээлийн шударга, нээлттэй, ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай шалгуур үзүүлэлт, дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоож, хэрэгжилтийг хангах;

4.1.3. Зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд болон тухайлсан үнэт цаасны хувьд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, санал дэвшүүлж, шийдвэрлүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

4.1.4. Зах зээлийг хөгжүүлэхэд шаардлагатай салбарын дэд бүтцийг сайжруулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлж ажиллах;

4.1.5. Үнэт цаасны зах зээлийн мэдээлэл солилцох, харилцан туслалцаа үзүүлэх зорилгоор гадаад улсын эрх бүхий зохицуулалтын байгууллагуудтай хамтран ажиллах;

4.1.6. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд мэргэжлийн холбоод, зохицуулалтын байгууллагууд болон төрийн бусад байгууллагуудаас санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, танилцуулга хийх.

4.2. Санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн чиглэлээр:

4.2.1. Үнэт цаасны зах зээлийн бүх төрлийн санхүүгийн хэрэгслийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбогдсон харилцааг зохицуулах;

4.2.2. Анхдагч зах зээлд үнэт цаас арилжаалах зөвшөөрлийг олгох, анхдагч зах зээлийн арилжааны тайлан мэдээг авч, хянах, арилжаа хуулийн дагуу явагдсан эсэхэд мониторинг хийх,

арилжаа амжилттай явагдсан тохиолдолд хоёрдогч зах зээлд арилжаалах эрх олгох асуудлыг шийдвэрлүүлэх;

4.2.3. Бүртгэсэн үнэт цаасыг зах зээлд гаргасан эсэхэд хяналт тавьж, гаргаагүй тохиолдолд бүртгэлийг хүчингүй болгох эсэх асуудлыг шийдвэрлүүлэх;

4.2.4. Суурь үнэт цаасаар гэрчлэгдэх өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрх, үүргийг баталгаажуулах, Монгол улсын болон гадаад улсын хадгаламжийн бичигтэй холбоотой Хорооны хэрэгжүүлэх үүргийн биелэлтийг хангаж ажиллах;

4.2.5. Үнэт цаасны анхдагч зах зээлтэй холбоотой мэдээ, мэдээллийг хянаж, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах;

4.2.6. Олон улсын байгууллагаас гаргасан зарчим, стандарт, хэм хэмжээг нэвтрүүлэх чиглэлээр холбогдох судалгааг хийж, зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчдыг зах зээлд татах нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.7. Шинэ бүтээгдэхүүний зах зээл, дэд бүтэцтэй холбоотой судалгаа шинжилгээг хийж, бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой зах зээлийн төлөв байдлын эрсдлийг тооцох, санал дүгнэлт гаргаж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;

4.2.8. Зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, шудрага өрсөлдөөнийг бий болгох үүднээс үнэт цаас гаргагчаас төлөх зохицуулалтын үйлчилгээний хөлсний стандарт, хэм хэмжээг зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаас гаргагчдын санхүүгийн чадавхид нийцүүлэхтэй холбоотой саналыг боловсруулан шийдвэрлүүлэх;

4.2.9. Зах зээлд оролцогчийг танин мэдэх, зах зээлийг эрсдэлд оруулж болзошгүй нөхцөл байдлыг тодорхойлох аргачлалыг бий болгож, стандарт хэм хэмжээг нарийвчлан тогтоож, зах зээлийг эрсдлээс хамгаалах;

4.2.10. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний талаар олон нийтэд мэдээлэл хүргэх, таниулах.

4.3. Мэргэжлийн оролцогчдын чиглэлээр:

4.3.1. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдэд үйл ажиллагааны чиглэлээр тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох, бүртгэхэд хуулиар тавьсан шалгуур, шаардлагыг хангасан эсэхийг хянах, дүгнэлт гаргах;

4.3.2. Үнэт цаасны зах зээлд оролцох зохицуулалттай этгээдийн чадавхийг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх, ил тод, нээлттэй, шударга ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, үйл ажиллагааны стандарт, ёс зүйн хэм хэмжээг тогтоох;

4.3.3. Зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах,

4.3.4. Зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, шудрага өрсөлдөөнийг бий болгох үүднээс зохицуулалттай этгээдээс төлөх зохицуулалтын үйлчилгээний хөлсний стандарт, хэм хэмжээг тогтоох;

4.3.5. Өөрийгээ зохицуулах байгууллагыг бүртгэх, тэдгээрийн батлан мөрдүүлж буй дүрэм, журмууд хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавих;

4.3.6. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон зохицуулалттай этгээдийн харилцагчид, харилцагчдын хөрөнгийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

ТАВ. ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Даатгалын зах зээлийн хөгжлийн ойрын ирээдүйн болон хэтийн зорилтуудыг тодорхойлох, зах зээлд тулгамдсан болон тулгарч болзошгүй системийн хүндрэл бэрхшээлүүдийг урьдчилан тодорхойлох эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх, даатгуулагч төвтэй хүртээмжтэй даатгалын зах зээлийн хөгжлийн бодлого зохицуулалтыг хөгжүүлэх, даатгалын

бүтээгдэхүүн үйлчилгээний зуучлалыг хөгжүүлэх, даатгалын зах зээл дэх шудрага өрсөлдөөний орчин нөхцлийг бүрдүүлэх, даатгалын мэргэжлийн үйл ажиллагааг хөгжүүлэх, давхар даатгалын дотоодын болон олон улсын зах зээлийн оролцоог хөгжүүлэх, хөрөнгийн зах зээлд оролцох хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, энэ ажлын хүрээнд мэргэжлийн холбоод, даатгалын байгууллагууд болон төрийн бусад байгууллагуудаас санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, танилцуулга хийх чиглэлээр Даатгалын зах зээлийн зохицуулалтын хэлтэс, Даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний хэлтэс гэсэн бүтэцтэйгээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1. Даатгалын зах зээлийн зохицуулалтын чиглэлээр:

5.1.1. Даатгалын зах зээлийн судалгаа хийх, ерөнхий багтаамжийг даатгалын төрөл тус бүрээр тодорхойлох, даатгалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох,

5.1.2. Даатгалын зах зээлийн мэдээллийн сангийн үндсэн өгөгдхүүнүүдийг тодорхойлох, газрын хэмжээнд үүсгэсэн мэдээллийг нэгтгэж, зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд өгөх,

5.1.3. Даатгалын үйл ажиллагааны зарим тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох шийдвэрийн төслийн санал боловсруулах, дүгнэлт гаргуулах, хянуулах, танилцуулах, хуралдаанд оруулж хуулийн хугацаанд шийдвэрлүүлэх;

5.1.4. Даатгалын компанийн хөрөнгийн хүрэлцээтэй байдал, төлбөрийн чадварын зохистой харьцааг эрсдэлд суурилсан зарчмаар тооцоолох аргачлалыг боловсруулах хөгжүүлэх талаар Бодлого зохицуулалт хариуцсан нэгжтэй хамтран ажиллах, нэвтрүүлэх;

5.1.5. Даатгалын зах зээлийн хүний нөөцийн ойрын болон хэтийн нэгдсэн бодлого, их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийн агуулгыг даатгалын зах зээлийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах бодлогыг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх;

5.1.6. Даатгалын мөн чанар, эрсдлийн удирдлагын талаар олон нийтэд ухуулж сурталчлах, соён гэгээрүүлэх, санхүүгийн боловсрол олгох бодлого арга зүйг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх;

5.1.7. Даатгуулагч төвтэй даатгалын зах зээлийн тогтолцоог бий болгох, даатгагчийн талаарх санхүүгийн мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангах хөтөлбөр арга хэмжээнүүд боловсруулах;

5.1.8. Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд даатгалын салбарыг институцийн хөрөнгө оруулагчийн түвшинд татан оролцуулах хууль эрх зүй, санхүүгийн таатай орчинг бүрдүүлэх үе шаттай хөтөлбөр боловсруулах, даатгалын компаниудын нөөц сангийн хөрөнгийг эрэмбэлэх;

5.1.9. Даатгалын салбарын гадаад харилцааг бүс нутгийн болон олон улсын түвшинд эрчимтэй хөгжүүлэх, дэвшилтэт технологи, ноу хау-г даатгалын зах зээлд нэвтрүүлэх;

5.1.10. Төр засгийн эдийн засаг санхүүгийн макро бодлоготой даатгалын зах зээлийн хөгжлийн болон зохицуулалтын асуудлыг уялдуулах;

5.1.11. Санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэх, нийгмийн халамжийн бодлогыг зорилтот бүлэгт чиглүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт болон экспортыг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих бодлогын чиглэлүүдэд даатгалын зах зээлийн оролцоог нэмэгдүүлэх, ДНБ-д эзлэх даатгалын салбарын хувь оролцоог өсгөх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;

5.1.12. Даатгалын компаниудын чадавхийг бэхжүүлэх, нэмэгдүүлэх талаар хөтөлбөр арга хэмжээг мэргэжлийн холбоодын оролцоотойгоор боловсруулах, хэрэгжүүлэх;

5.1.13. Дотоод болон гадаад давхар даатгалын бодлого, хөтөлбөр боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх;

5.1.14. Үндэсний хэмжээний мега төслүүд дээр даатгалын зах зээлийн оролцоог хангах;

5.1.15. Даатгалын байгууллагуудын зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, түүнийг тогтоох аргачлал боловсруулах

5.2. Даатгалын бүтээгдэхүүн, хөгжлийн чиглэлээр:

- 5.2.1. Даатгуулагчид ээлтэй даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх талаар судалгаа хийх, эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- 5.2.2. Даатгалын бүтээгдэхүүн хүртээмжтэй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- 5.2.3. Даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний чөлөөт, шударга өрсөлдөөнийг дэмжиж ажиллах;
- 5.2.4. Даатгалын андеррайтингийн системийг боловсронгуй болгох орчин нөхцөлийг бүрдүүлэх;
- 5.2.5. Даатгалын хохирол барагдуулалтын системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- 5.2.6. Даатгалын актуарын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
- 5.2.7. Актуарчийн сургалт зохион байгуулах, үйл ажиллагаа эрхлэх эрх олгох;
- 5.2.8. Даатгалын хэлбэр болон даатгалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлийг судлах, хянах, зөвшөөрөх эсэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх;
- 5.2.9. Даатгагчийн зах зээл дээр борлуулж буй даатгалын бүтээгдэхүүний нөхцөл, шаардлагыг хянах, сайжруулах арга хэмжээ авч ажиллах;
- 5.2.10. Даатгалын цэвэр хураамжийн хувь хэмжээг хянах, нөөц сангийн мөнгөн хөрөнгө бүрдэх нөхцлийг бий бологох;
- 5.2.11. Албан журмын даатгалын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

ЗУРГАА. БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Бичил санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, салбарын эрсдэлийн болон бүтээгдэхүүн хөгжлийн судалгаа хийх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бичил санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх бодлого, зохицуулалтаар хангах, банк бус санхүүгийн зарим төрлийн үйл ажиллагааны эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дүгнэлт гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үндсэн үүрэг бүхий Бичил санхүүгийн зах зээлийн зохицуулалтын хэлтэс, Бичил санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийн хэлтэс гэсэн бүтэцтэйгээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1. Бичил санхүүгийн зохицуулалтын чиглэлээр

- 6.1.1. Бичил санхүүгийн салбарын тогтвортой хөгжлийг хангах, зах зээлд оролцогчдын үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал, төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх;
- 6.1.2. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд мэргэжлийн холбоод, зохицуулалтын байгууллагууд болон төрийн бусад байгууллагуудаас санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, танилцуулга хийх.
- 6.1.3. Бичил санхүүгийн зах зээлийн шударга, нээлттэй, ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай шалгуур үзүүлэлт, дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоох;
- 6.1.4. Судалгаа, шинжилгээний үндсэн дээр зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, төлөвлөгөө, санал дэвшүүлж, шийдвэрлүүлэх;
- 6.1.5. Зах зээлийг хөгжүүлэх хүрээнд салбарын дэд бүтцийг сайжруулах, хөрөнгө оруулагчдын хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, цар хүрээг тэлэх санал боловсруулах, шийдвэрлүүлэх;
- 6.1.6. Зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, шудрага өрсөлдөөнийг бий болгох үүднээс зохицуулалттай этгээдээс төлөх зохицуулалтын үйлчилгээний хөлсний стандарт, хэм

хэмжээг зах зээлийн хөгжлийг дэмжих, санхүүгийн чадавхид нийцүүлэхтэй холбоотой саналыг боловсруулан шийдвэрлүүлэх;

6.1.7. Бичил санхүүгийн зах зээлтэй холбоотой мэдээлэл солилцох, харилцан туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах зорилгоор салбарын мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах.

6.2. Бичил санхүүгийн бүтээгдэхүүн, хөгжлийн чиглэлээр:

6.2.1. Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой судалгаа шинжилгээг хийх, бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой зах зээлийн төлөв байдлын эрсдэлийг тооцох, санал дүгнэлт гаргаж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;

6.2.2. Бичил санхүүгийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, зээлийн хүү, эх үүсвэрийн өртөгийг бууруулах чиглэлээр санал боловсруулах;

6.2.3. Банк бус санхүүгийн зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дүгнэлт гаргах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр Хорооны холбогдох нэгжтэй хамтарч ажиллах;

6.2.4. Бичил санхүүгийн зах зээлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар судалгаа хийх, нэвтрүүлэх талаар санал боловсруулах;

6.2.5. Бичил санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар олон нийтэд мэдээлэл хүргэх, таниулах.

ДОЛОО. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР:

Санхүүгийн зах зээл, түүнд оролцогчдын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд шаардлага, шалгуур, санхүү, төлбөрийн чадварын зохистой харьцааны биелэлтийг шалгах, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд зохистой харьцаа алдагдсан, төлбөрийн чадваргүй болсон бол хууль тогтоомж, холбогдох журамд заасан албадлагын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчид болон харилцагчдын эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүрэг бүхий Үнэт цаасны хяналтын хэлтэс, Даатгалын хяналтын хэлтэс, Бичил санхүүгийн хяналтын хэлтэс болон Хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах хэлтэс гэсэн бүтэцтэйгээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1. Үнэт цаасны хяналтын чиглэлээр:

7.1.1. Зайны хяналтын чиглэлээр:

а/ Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч, хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн бирж, түүний зуучлагчийн үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, тэдгээрийн бүтэц, зохион байгуулалт, байршил, эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадвартай холбоотой үзүүлэлтүүдээр тайлан, мэдээ, судалгаа гаргуулан авч, тайлан, мэдээг холбогдох үзүүлэлтүүдээр нь тулган шалгаж, гүйлгээ, залруулга, тохируулга хийж үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварын талаар дүгнэлт гаргах;

б/ Газар дээрх хяналт шалгалтын тайлан, дүгнэлттэй уялдуулан үнэт цаасны зах зээлийн системийн хэмжээгээр нэгтгэсэн дүгнэлт гаргах, зах зээлийн судалгаа, хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын нэгдсэн бодлого боловсруулахад ашиглах;

в/ Ирүүлсэн тайлан, мэдээ, мэдээлэл хянах явцад илэрсэн зөрчил, дутагдлыг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийнхээ хүрээнд арилгуулах арга хэмжээг тухай бүр авах, шаардлагатай гэж үзвэл удирдлагад танилцуулж газар дээр хийх шалгалтын удирдамжид тусгуулж, түүний биелэлтэд хяналт тавьж ажиллах;

г/ Ирүүлсэн тайлан, мэдээ, мэдээлэл, судалгааг хуулийн этгээд тус бүрээр болон системийн хэмжээгээр он дараалсан үзүүлэлтээр хотлөн баяжуулах;

д/ Эрсдэл, хэтийн төлөв байдлын талаар таамаглал хийж удирдлагад саналаа танилцуулж, шийдвэрлүүлж хэрэгжүүлэх;

е/ Зайнаас тавих хяналтыг боловсронгуй болгохтой холбогдсон дүрэм, журмын төсөлд санал өгөх, техник хэрэгсэл, программ хангамжийг боловсронгуй болгох чиглэлээр санал дүгнэлт боловсруулж, шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авах;

ё/ Үнэт цаасны зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны стандарт, ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх.

ж/ хууль бус арилжаа явуулах, дотоод мэдээлэл ашиглах, зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх

7.1.2. Хяналт шалгалтын чиглэлээр:

а/ Батлагдсан хуваарийн дагуу газар дээрх шалгалт хийх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангах;

б/ Зайны хяналтын урьдчилсан дүгнэлт, өнгөрсөн хугацаанд хийсэн шалгалтын үр дүнгийн талаар бичсэн танилцуулга, тогтоосон акт, бусад баримт бичгүүдийг үндэслэн газар дээрх хяналт шалгалтын удирдамжийг батлуулах;

в/ Хяналт шалгалтыг шуурхай, хараат бус бие даасан байдлаар, хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээний хүрээнд хийж, газар дээрх хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг тогтоосон хугацаанд удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх;

г/ Үнэт цаасны зах зээлийн хэрэг, зөрчил болон бусад гэмт хэргийн шинжтэй үйлдэлд хяналт шалгалт хийх чиглэлээр холбогдох бусад хяналт, зохицуулалтын байгууллага болон шүүх, прокурор, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах;

д/ Хууль, хяналтын байгууллагын шийдвэр, хүсэлтээр шинжээчээр ажиллах, шалгалт хийх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

е/ Үнэт цаасны зах зээлийн арилжааны ил тод байдал, дотоод мэдээлэл ашиглаж арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглах үйлдэлд хяналт тавих;

ё/ Чиг үүргийн хүрээнд захиргааны хариуцлага ногдуулах, энэ төрлийн зөрчлийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх, гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл хууль хяналтын байгууллагад мэдээлэл хүргэх, шалгуулахаар шилжүүлэх;

ж/ Хяналт шалгалтын нэгдсэн тайлан гаргаж, нэгтгэлийг удирдлагад танилцуулж, мэдээллийн нэгдсэн санд хадгалж байх;

7.2. Даатгалын хяналтын чиглэлээр:

7.2.1. Зайны хяналтын чиглэлээр:

а/ Даатгалын байгууллага, даатгалын мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, тэдгээрийн бүтэц, зохион байгуулалт, байршил, эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадвартай холбоотой үзүүлэлтүүдээр тайлан, мэдээ, судалгаа гаргуулан авч, тайлан, мэдээг холбогдох үзүүлэлтүүдээр нь тулган шалгаж, гүйлгээ, залруулга, тохируулга хийж үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварын талаар дүгнэлт гаргах;

б/ Газар дээрх хяналт шалгалтын тайлан, дүгнэлттэй уялдуулан даатгалын зах зээлийн системийн хэмжээгээр нэгтгэсэн дүгнэлт гаргах, зах зээлийн судалгаа, хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын нэгдсэн бодлого боловсруулахад ашиглах;

в/ Ирүүлсэн тайлан, мэдээ, мэдээлэл хянах явцад илэрсэн зөрчил, дутагдлыг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийнхээ хүрээнд арилгуулах арга хэмжээг тухай бүр авах,

шаардлагатай гэж үзвэл удирдлагад танилцуулж, газар дээр хийх шалгалтын удирдамжид тусгуулж, түүний биелэлтэд хяналт тавьж ажиллах;

г/ Ирүүлсэн тайлан, мэдээ, мэдээлэл, судалгааг хуулийн этгээд тус бүрээр болон системийн хэмжээгээр он дараалсан үзүүлэлтээр хөтлөн баяжуулах;

д/ Эрсдэл, хэтийн төлөв байдлын талаар таамаглал хийж удирдлагад саналаа танилцуулж, шийдвэрлүүлж хэрэгжүүлэх;

е/ Зайнаас тавих хяналтыг боловсронгуй болгохтой холбогдсон дүрэм, журмын төсөлд санал өгөх, техник хэрэгсэл, программ хангамжийг боловсронгуй болгох чиглэлээр санал дүгнэлт боловсруулж, шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авах;

ё/ Даатгалын зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны стандарт, ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх.

7.2.2. хяналт шалгалтын чиглэлээр:

а/ Батлагдсан хуваарийн дагуу газар дээрх шалгалт хийх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангах;

б/ Зайны хяналтын албанаас ирүүлсэн урьдчилсан хяналтын дүн, өнгөрсөн хугацаанд хийсэн шалгалтын үр дүнгийн талаар бичсэн танилцуулга, тогтоосон акт, бусад баримт бичгүүдийг үндэслэн газар дээрх хяналт шалгалтын удирдамжийг батлуулах;

в/ Хяналт шалгалтыг шуурхай, хараат бус бие даасан байдлаар, хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээний хүрээнд хийж, тайлан холбогдох танилцуулга, дүгнэлтийг тогтоосон хугацаанд удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх;

г/ Санхүүгийн зах зээлийн хэрэг, зөрчил болон бусад гэмт хэргийн шинжтэй үйлдэлд хяналт шалгалт хийх чиглэлээр холбогдох бусад хяналт, зохицуулалтын байгууллага болон шүүх, прокурор, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах;

д/ Хууль, хяналтын байгууллагын шийдвэр, хүсэлтээр шинжээчээр ажиллах, шалгалт хийх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

е/ Чиг үүргийн хүрээнд захиргааны хариуцлага ногдуулах, энэ төрлийн зөрчлийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх, гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл хууль хяналтын байгууллагад мэдээлэл хүргэх, шалгуулахаар шилжүүлэх;

ё/ Хяналт шалгалтын нэгдсэн тайлан гаргаж, нэгтгэлийг удирдлагад танилцуулж, мэдээллийн нэгдсэн санд хадгалж байх;

7.3. Бичил санхүүгийн хяналтын чиглэлээр:

7.3.1. Зайны хяналтын чиглэлээр:

а/ Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, тэдгээрийн бүтэц, зохион байгуулалт, байршил, эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадвартай холбоотой үзүүлэлтүүдээр тайлан, мэдээ, судалгаа гаргуулан авч, тайлан, мэдээг холбогдох үзүүлэлтүүдээр нь тулган шалгаж, гүйлгээ, залруулга, тохируулга хийж үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварын талаар дүгнэлт гаргах;

б/ Газар дээрх хяналт шалгалтын тайлан, дүгнэлттэй уялдуулан бичил санхүүгийн зах зээлийн системийн хэмжээгээр нэгтгэсэн дүгнэлт гаргах, зах зээлийн судалгаа, хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын нэгдсэн бодлого боловсруулахад ашиглах;

в/ Ирүүлсэн тайлан, мэдээ, мэдээлэл хянах явцад илэрсэн зөрчил, дутагдлыг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийнхээ хүрээнд арилгуулах арга хэмжээг тухай бүр авах,

шаардлагатай гэж үзвэл удирдлагад танилцуулж, Хяналт шалгалтын албанд өгч газар дээр хийх шалгалтын удирдамжид тусгуулж, түүний биелэлтэд хяналт тавьж ажиллах;

г/ Ирүүлсэн тайлан, мэдээ, мэдээлэл, судалгааг хуулийн этгээд тус бүрээр болон системийн хэмжээгээр он дараалсан үзүүлэлтээр хөтлөн баяжуулах;

д/ Эрсдэл, хэтийн төлөв байдлын талаар таамаглал хийж удирдлагад саналаа танилцуулж, шийдвэрлүүлж хэрэгжүүлэх;

е/ Зайнаас тавих хяналтыг боловсронгуй болгохтой холбогдсон дүрэм, журмын төсөлд санал өгөх, техник хэрэгсэл, программ хангамжийг боловсронгуй болгох чиглэлээр санал дүгнэлт боловсруулж, шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авах;

ё/ Бичил санхүүгийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны стандарт, ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх.

ж/ Хяналт шалгалтын албаны хяналт шалгалтын дүнтэй харьцуулж, дүгнэлт хийх;

7.3.2. хяналт шалгалтын алба:

а/ Батлагдсан хуваарийн дагуу газар дээрх шалгалт хийх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангах;

б/ Зайны хяналтын албанаас ирүүлсэн урьдчилсан хяналтын дүн, өнгөрсөн хугацаанд хийсэн шалгалтын үр дүнгийн талаар бичсэн танилцуулга, тогтоосон акт, бусад баримт бичгүүдийг үндэслэн газар дээрх хяналт шалгалтын удирдамжийг батлуулах;

в/ Хяналт шалгалтыг шуурхай, хараат бус бие даасан байдлаар, хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээний хүрээнд хийж, тайлан холбогдох танилцуулга, дүгнэлтийг тогтоосон хугацаанд удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх;

г/ Санхүүгийн зах зээлийн хэрэг, зөрчил болон бусад гэмт хэргийн шинжтэй үйлдэлд хяналт шалгалт хийх чиглэлээр холбогдох бусад хяналт, зохицуулалтын байгууллага болон шүүх, прокурор, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах;

д/ Хууль, хяналтын байгууллагын шийдвэр, хүсэлтээр шинжээчээр ажиллах, шалгалт хийх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

е/ Чиг үүргийн хүрээнд захиргааны хариуцлага ногдуулах, энэ төрлийн зөрчлийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэх, гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл хууль хяналтын байгууллагад мэдээлэл хүргэх, шалгуулахаар шилжүүлэх;

ё/ Хяналт шалгалтын нэгдсэн тайлан гаргаж, нэгтгэлийг удирдлагад танилцуулж, мэдээллийн нэгдсэн санд хадгалж байх;

7.4. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр:

7.4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, гомдлыг барагдуулах талаар санал дүгнэлт гаргаж, шийдвэрлэх;

7.4.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хянан шийдвэрлэх;

7.4.3. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд хамгаалах;

7.4.4. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийг төлөөлж хууль, шүүхийн байгууллагад хандах, тэдний эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалах;

7.4.5. Эрх ашиг нь зорчигдсон хорогдоо оруулагчдын хохирлыг барагдуулах талаар хуулийн хүрээнд шаардлагатай арга хэмжээ авч ажиллах;

7.4.6. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх асуудлаар санал гаргаж, шийдвэрлүүлэх;

7.4.7. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;

7.4.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх нийтэд хүргэж буй мэдээлэл, сурталчилгаанд хяналт тавих;

НАЙМ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Санхүүгийн зохицуулах хороог Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, дүрэм болон хууль тогтоомжийн бусад актад заасан үйл ажиллагааны чиглэл, зорилтоо биелүүлэх нөхцлийг хангах үндсэн үүрэг бүхий Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтэс /Захиргаа, хүний нөөцийн алба, Санхүү, хангамжийн алба, Дотоод алба/ Эрх зүйн хэлтэс Сургалт, сурталчилгааны хэлтэс / Сургалтын алба, Хорооны үйл ажиллагааг сурталчлах алба/, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс /Протоколын алба, Төсөл, хөтөлбөрийн нэгж/, Мэдээлэл технологийн хэлтэс гэсэн бүтэцтэйгээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1. Захиргаа, нийтлэг үйлчилгээний чиглэлээр:

Санхүүгийн зохицуулах хорооны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахад хүний нөөцийн бодлого, хэрэгжилт, санхүү хангамж, ажилтан албан хаагчдын хөдөлмөрийн харилцаа, Хорооны хуралдааныг зохион байгуулалт, төлөвлөгөө, тайлангийн нэгтгэл, архив, албан бичиг хэргийн хөтлөлт зэрэг асуудлуудыг нэгтгэн дараах албадуудаар зохион байгуулж хэрэгжүүлнэ.

8.1.1. Захиргаа, хүний нөөцийн алба:

а/ Санхүүгийн зохицуулах хорооны аппаратыг цомхон, чадварлаг, мэдлэг, чадвартай ажилтнуудаар бүрдүүлж, санхүүгийн олон талт мэдлэг бүхий тогтвор, суурьшилтай хүний нөөцтэй байх хүний нөөцийн бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангах, хүний нөөцөө тасралтгүй хөгжүүлж ажиллах;

б/ Хүний нөөцөө Монгол улсын болон гадаад улсын их дээд сургуулийг санхүү, банк, нягтлан бодох бүртгэлээр амжилттай төгссөн, үнэт цаас, даатгал, эдийн засаг, банк, санхүү, бизнесийн хууль эрх зүйгээр мэргэшсэн хүмүүсээс сонгон шалгаруулж, бэлтгэж байх;

г/ Ажлын байранд хүний нөөцөө зөв байршуулж, хөдөлмөрийн үр бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын байрны тодорхойлолтонд дүн шинжилгээ хийх боловсронгуй болгох санал боловсруулах;

д/ Ажиллагсаддаа төрийн бусад байгууллагуудтай өрсөлдөхүйц хэмжээний цалин олгож, сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

е/ Ажилтнуудтай хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх, хувийн хэргийг стандартын дагуу бүрдүүлэх, хадгалах, хүний нөөцтэй холбоотой бүртгэл, мэдээ, судалгаа, тайлан гаргах;

ё/ Ажилтныг ажилд авах, ажлаас чөлөөлөх, цалин хөлс, нөхөн олговор олгох, тэдний ажил мэргэжлийн түвшинг үнэлэх, албан хаагчдад зэрэг дэв олгох, ур чадварын нэмэгдэл, урамшуулал олгох, шагналд тодорхойлох, шийтгэл ногдуулах зэрэг ажлыг хууль тогтоомжийн дагуу судалж, шийдвэрийн төсөл бэлтгэж, удирдах албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

ж/ Хорооны үйл ажиллагаанд хамаарах дээд газрын тогтоол, шийдвэрийн бүртгэл хөтлөх, хэрэгжилтийг хангуулах, биелэлтийг нэгтгэн удирдлагад танилцуулах, холбогдох газарт хүргүүлэх;

з/ Хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хөтөлбөрийг нэгтгэх;

и/ Хорооны Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журмыг боловсруулах, мөрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих

8.1.2. Дотоод ажлын алба:

- а/ Санхүүгийн зохицуулах хороо, Хяналтын зөвлөл, Компанийн засаглалын Үндэсний зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, шийдвэрийг албажуулах;
- б/ Санхүүгийн зохицуулах хороо, Хяналтын зөвлөл, Компанийн засаглалын Үндэсний зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, биелэлтийг нэгтгэх;
- в/ Хорооны орон нутаг дахь төлөөлөгчдийн бүртгэл, хөдөлгөөнийг хөтлөх, үйл ажиллагааны тайланг нэгтгэх;
- г/ Хорооны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хөтлөн явуулах;
- д/ Хорооны архивын үйл ажиллагааг хөтлөн явуулах;
- е/ Хорооны нууцын баримт бичгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг хариуцан гүйцэтгэх;
- ё/ Хорооны үйл ажиллагаанд хэрэглэгдэх хэвлэмэл хуудасны ашиглалт, хадгалалтыг хариуцан ажиллах, хэвлэмэл хуудас дээр баримт бичгийг хэвлэн гаргах;
- ж/ Хорооны тамга тэмдгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцан ажиллах;
- з/ Хороо болон ажилтнуудын хэвлэл захиалгыг хийх, хүргэх;
- и/ Хорооны дотоод вэб хуудас, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт/KPI/-д мэдээлэл оруулах ажлыг зохион байгуулах;
- й/ Хорооны дарга, орон тооны гишүүн, Ажлын албаны даргын уулзалтыг зохион байгуулах, хэвийн ажиллах нөхцөлийг хангах.

8.1.3. Санхүү, хангамжийн алба:

- а/ Санхүүгийн зохицуулах хорооны аж ахуй, санхүүгийн менежментийг хэрэгжүүлэх;
- б/ Хорооны жил бүрийн төсвийн төслийг боловсруулж, хуульд заасан хугацаанд Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
- в/ Батлагдсан төсвийг зохих журмын дагуу зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах;
- г/ Хорооны орлогын төлөвлөгөөний явц, биелэлтэд хяналт тавих;
- д/ Хорооны нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, холбогдох байгууллагуудад хүргүүлэх;
- е/ Төсвийн болон Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн бэлтгэл ажил, биелэлтийг хариуцах, ханган ажиллах.
- ё/ Хорооны эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт, техник хэрэгслийн засвар үйлчилгээ болон албан ажлын зориулалттай шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бичиг хэргийн хэрэгслийн жагсаалт гарган хангах ажиллагааг шуурхай зохион байгуулах, хэмнэлттэй зарцуулахад хяналт тавих;

8.2. Эрх зүйн чиглэлээр:

8.2.1. Санхүүгийн зах зээлийг зохицуулж буй хууль тогтоомжийн хүрээнд болон Төрийн алба, хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцийн асуудлаар Хорооноос болон Хорооны дарга, Ажлын албаны даргын тушаал, шийдвэрийн төслийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж, хууль тогтоомжид нийцүүлэх, зөвтгүүлэх;

8.2.2. Санхүүгийн зах зээлийн салбарын болон бусад холбогдох салбарын хууль тогтоомж, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулахад санал өгөх, төсөл боловсруулах, Ажлын хэсэгт ажиллах;

8.2.3. Санхүүгийн зах зээлийг зохицуулж буй хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт, дүрэм, журмын төсөл /нэмэлт, өөрчлөлт, шийнэчилсэн найруулга/-ийг хянах, стандартад оруулах, батлагдсан журмыг улсын бүртгэлд бүртгүүлэх, кодификаци хийх;

8.2.4. Хууль тогтоомжийн хүрээнд зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаандаа мөрддөг дүрэм, журам, зааварт өөрчлөлт орох тухай бүр тухайн өөрчлөлтийг хянах, зөвтгүүлэх, зөвшөөрөх;

8.2.5. Хорооноос бусад байгууллага, тэтгээдтэй байгуулах гэрээ, хэлцэл, хэлэлцээр, хамтын ажиллагааны баримт бичгийн төсөл боловсруулах, төслийг хуульд нийцүүлэн хянах, зөвтгүүлэх, зөвшөөрөх;

8.2.6. Хорооны газар, хэлтэс, нэгжийн үйл ажиллагаанд эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэх, хууль, эрх зүйн баримт бичгийн цахим болон цаасан хэлбэрээр лавлагааны санг бүрдүүлж, ашиглуулах;

8.2.7. Хорооны үйл ажиллагаатай холбоотой аливаа зөрчил, маргаантай асуудлаар хууль хяналтын байгууллагад итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлж, тайлбар гаргаж, нотлох баримтыг бүрдүүлэх зэргээр хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;

8.2.8. Хорооны улсын байцаагчдаас тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд ногдуулсан захиргааны шийтгэлийн бүртгэл хөтлөх, захиргааны хэрэг бүртгэх ажиллагаанд хууль эрх зүйн зүйн туслалцаа, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

8.2.9. Авлигын эсрэг Хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах, ажилтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийн бүртгэл хөтлөх, хадгалах эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

8.2.10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг Хорооны хэмжээнд зохицуулалтаар хангах.

8.3. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:

Санхүүгийн зохицуулах хорооноос гадаад орнуудын ижил төстэй байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн мэргэжлийн холбоод, олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, донор орнуудтай харилцах бодлогыг боловсруулах, тэдгээрийн өмнө Хорооны хүлээсэн үүргийг биелүүлэх, харилцаа хамтын ажиллагааг идэвхижүүлэх, өргөжүүлэн хөгжүүлэх ажлыг нэгтгэн зохион байгуулж хэрэгжүүлэх

8.3.1. Протоколын алба:

а/ Хорооны гадаад хамтын ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг улирал, жилээр тайлагнах;

б/ Хорооноос гадаад улсуудын Засгийн газар, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдтэй байгуулах гэрээ, хэлэлцээрийн төсөл бэлтгэх, санал дүгнэлт өгөх;

в/ Гадаад орнуудын ижил төстэй байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагууд болон мэргэжлийн холбоодтой байгуулах гэрээ, хэлэлцээр, хамтран ажиллах санамж бичгийн төсөл бэлтгэх, санал дүгнэлт өгөх;

г/ Хорооноос оролцох олон улсын чанартай хурал, зөвлөлгөөний бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах, үр дүнг хариуцах, биелэлтийг тайлагнах;

д/ Хорооны удирдлагад гадаад хамтын ажиллагааны чиглэлээр зөвөлгөө өгөх шаардлагатай танилцуулга мэдээллээр хангах, уулзалтын тэмдэглэл хөтлөх, уулзалтаар өгөгдсөн үүрэг даалгаврыг албажуулах, Хорооны холбогдох нэгжид хүргүүлэх, түүний биелэлтийг хариуцан ажиллах, үр дүнг тайлагнах;

е/ Хорооны тайлан, танилцуулга, захидал, илгээмж, мэндчилгээ, цахим хуудсанд оруулах материал, шаардлагатай бичиг баримтыг орчуулах;

ё/ Хорооны удирдлагын гадаад айлчлал болон ажилтнуудыг олон улсын сургалт, семинарт хамруулах ажлыг зохион байгуулах;

з/ Хорооны ажилтныг гадаад сургалтад хамрагдах удирдамжийг хянах, батлуулах, сургалтанд хамрагдсан албан хаагчдын нэгдсэн бүртгэл хөтлөх, тайлан мэдээг улирал бүрээр гаргах;

8.3.2. Төсөл, хөтөлбөрийн нэгж:

а/ Гадаадын хандивлагчид, хөрөнгө оруулагчдын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, хэрэгжүүлэх боломж үйл ажиллагааг судлах, зохион байгуулах, үр дүнг хариуцах;

б/ Хорооны хэмжээнд хэрэгжиж байгаа гадаадын төсөл хөтөлбөрийн явц, хэрэгжилт, хэрэгжилт, уялдаа холбоог зохицуулах, нэгдсэн байдлыг хангаж ажиллах;

в/ Төслийн удирдах хорооны хурлыг улирал тутам зохион байгуулж хэрэгжилт үр дүнг хянаж ажиллах, тайлагнах;

8.4. Мэдээлэл технологийн чиглэлээр:

8.4.1. Санхүүгийн зохицуулах хороо болон Ажлын албаны үйл ажиллагааг хэвийн явуулах мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээллийн аюулгүй байдлыг зохих түвшинд хангах, компьютерийн сүлжээ болон түүнд суурилсан бүх төрлийн үйлчилгээг үзүүлэх ажлын эрхлэн гүйцэтгэнэ.

8.4.2. Хорооны үйл ажиллагаа, эрхэм зорилго, стратеги, мэдээллийн ба харилцаа холбооны технологийн салбарын стандарт, хөгжлийн чиг болон холбогдох хууль эрх зүйн зохицуулалтад нийцүүлэн нэгжийн үйл ажиллагааны бодлого, хэтийн зорилго ба зорилтуудыг тодорхойлох, шинэчлэх, хэрэгжүүлэлтийг хариуцах;

8.4.3. Хорооны мэдээллийн ба харилцаа холбооны технологийн болон мэдээллийн аюулгүй байдлын асуудлын хүрээнд холбогдох журам, заавар, ажлын горим зэргийг олон улсын туршлага, стандартуудад нийцүүлэн боловсруулж батлах, шинэчлэх;

8.4.4. Хороонд хуримтлагдаж буй мэдээллийн сангийн эрхлэлт, нууцлал, нөөцлөлт, мэдээллийн аюулгүй ба хүртээмжтэй байдал, бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах;

8.4.5. Ашиглагдаж буй програм хангамж, системийн найдвартай, үл тасалдах ажиллагаа, хөгжүүлэлт, өргөтгөл, шинэчлэлийг хариуцах, холбогдох төслийг удирдах, хянах. Оюуны өмчийн хууль ёсны хэрэглээг хангаж ажиллах;

8.4.6. Ашиглагдаж буй дотоод, гадаад сүлжээний эрхлэлт, найдвартай ажиллагаа, нууцлал, зохион байгуулалт, оновчлолыг хариуцах, хяналтыг тавьж энэ хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах;

8.4.7. Хорооны систем бүрийн цахим хэрэглэгчийн эрхийн удирдлагыг хэрэгжүүлэх;

8.4.8. Хорооны хэрэгцээнд ашиглагдаж буй өмчлөх болон эзэмших техник, тоног төхөөрөмж, компьютер, сервер, сүлжээний болон мэдээллийн аюулгүй байдлын төхөөрөмж, бусад техник, дагалдах хэрэгслийн найдвартай ажиллагаа, бүрэн бүтэн байдал, засвар үйлчилгээ, шинэчлэлийг хариуцах;

8.4.9. Хорооны албан цахим хуудасны хэвийн, найдвартай ажиллагааг хангах, шаардагдсан үед хөгжүүлэх, сайжруулах, шинэчлэх;

8.4.10. Ажлын албаны дотоод хэрэгцээний хаалттай цахим хуудасны хэвийн, найдвартай ажиллагааг хангаж ажиллах, шаардагдсан үед хөгжүүлэх, сайжруулах, шинэчлэх;

8.4.11. Хариуцсан чиг үүргийн холбогдох асуудлаар байгууллагын дотоод, шаардлагатай үед харилцагч байгууллагад сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгөх. Вебмастер буюу мэдээ оруулагч, хуудас эрхлэгчид сургалт явуулах, зөвлөмж өгч ажиллах;

8.4.12. Шаардлагатай тохиолдолд Хорооны хэрэгцээнд програм хангамж боловсруулах,;

8.4.13. Шаардлагатай тохиолдолд санхүүгийн салбарын үйлчилгээ үзүүлэгч байгууллагын мэдээллийн технологи, аюулгүй байдлын хүрээний зүйлд хяналт, үзлэг хийж, зөвлөмж хүргүүлэх ингэхдээ хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудлыг хамруулах.

8.5. Сургалт, сурталчилгааны чиглэлээр:

Аппаратын ажилтнууд болон зохицуулалттай этгээд, мэргэжлийн байгууллагуудын ажилласад, харилцагчид, хөрөнгө оруулагчид болон санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг хүргэх шаардлагатай нийгмийн бүлэг, хэсэгт зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгцээг хангах чадавхи бий болгох явдлыг дэмжиж ажиллана.

8.5.1. Сургалтын алба:

а/ Ажлын албаны ажилтнууд, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг хүргэх шаардлагатай нийгмийн бүлэг, хэсэгт зориулсан бүх төрлийн сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, сургалтын агуулга, хөтөлбөрийг батлуулах, сургагчийг сонгон шалгаруулах, сэдвийн захиалга хийх, зохион байгуулалтыг хариуцах, хяналт тавих ажлыг хийж гүйцэтгэх;

б/ Хорооноос хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид, зохицуулалттай этгээд болон мэргэжлийн байгууллагуудын ажилласдад зориулсан сургалтыг мэргэжлийн болон сургалтын бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

в/ Байгууллагын зардлаар суралцсан ажилтнуудтай гэрээ байгуулж, суралцсан сэдвийг бусад ажилтнуудад хүргэх лекц, семинарыг зохион байгуулах, суралтын гарын авлага материалыг нийт ажиллагсдад таниулж, мэдээлэх, ашиглуулах.

8.5.2. Хорооны үйл ажиллагааг сурталчилах алба:

а/ Хорооны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг зохион байгуулах, “Санхүүгийн зах зээлийн мэдээлэл” сэтгүүлийг эмхлэн гаргах ажлыг хариуцах;

б/ Хорооны хуралдаанаас гаргасан шийдвэрийн талаар зах зээлд оролцогчдод хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, хорооны үйл ажиллагааны талаар танилцуулга, сурталчилгааны бусад мэдээлэл бэлтгэн нийтлүүлэх, эмхтгэж хэвлүүлэх;

в/ Хорооны удирдлага, ажилтнуудаар зах зээлийн байдал, цаг үеийн асуудлаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгүүлэх ажлыг зохион байгуулах, Хорооны үйл ажиллагаатай холбоотой гэрэл зургийн архив бүрдүүлэх, видео сан бий болгох;

БС. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС:

9.1. Санхүүгийн зохицуулах хорооноос иргэд, хуулийн этгээдэд олгож буй тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох, бүртгэх ажиллагааг шуурхай зохион байгуулж, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдэд хялбар, ил тод, нээлттэй байдлаар үйлчлэх нөхцлийг бүрдүүлэх, Хороо болон Хорооны даргын шийдвэрийн төслийг боловсруулах, дүгнэлт гаргуулах, хянуулах, танилцуулах, хуралдаанд оруулж хуулийн хугацаанд шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах үндсэн үүргийн хүрээнд дараахь чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана:

9.1.2. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох, бүртгэх, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийн тэмдэглэл хийх үйл ажиллагааг цахимжуулан зайнаас цахим шуудангаар өргөдөл, хүсэлт гаргах нөхцлийг бүрдүүлэх, цахим үйлчилгээний оновчтой тогтолцоог бий болгох, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, хадгалах, ашиглах;

9.1.3. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох хүсэлтийг хүлээн авах, ирүүлсэн баримт бичгийг ажил үүргийн хуваарийн дагуу нягталж шалгах, шаардлагатай баримт бичгийг гаргуулан авч бүрдлийг хангуулах, энэ чиглэлээр үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгөх;

9.1.4. Шаардлагатай тохиолдолд зөвшөөрөл хүсэгчийн санхүүгийн тайлан, бизнэс төлөвлөгөөний хэрэгжилт, эрсдлийн үнэлгээний талаар холбогдох нэгжээр дүгнэлт гаргуулах,

чиглэл хариуцсан нэгж дээр боловсруулагдаж буй зөвшөөрлийн баримт бичгийн бүрдүүлэлтийн явцад процессын хяналт тавих;

9.1.5. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох өргөдөл, хүсэлтийн баримт бичгүүдийг бүртгэн хяналтад авах, зөвхөн албан ажлын хэрэгцээнд нууцын баталгаатайгаар судалгаа, шинжилгээ хийх зорилгоор хяналтын картаар ашиглуулах.

АРАВ. ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

10.1. Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаа нь эрсдлийн зохистой удирдлагын бодлого, хэм хэмжээнд байгаа эсэхэд хяналт тавьж, дотоод хяналтын систем болон үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээллээр Хорооны дарга, гишүүд, Ажлын албаны газар, нэгж тэдгээрийн албан хаагчдыг хангах, Хорооны үйл ажиллагааны эрсдлийн түвшинд үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж, тайлан гаргаж, хэрэгжилтийг хангуулах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж гаргах үндсэн үүрэг бүхий Дотоод аудитын хэлтэс нь Хорооны удирдлагад ажлаа шууд тайлагнаж, дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана:

10.1.2. Хорооны стратеги зорилт, тогтоол шийдвэр болон хуралдаанаар өгсөн үүрэг даалгавар, жилийн ажлын төлөвлөгөө, бусад хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилт, уялдаа холбоотой байдалд хяналт тавьж, биелэлтийг хангуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах;

10.1.3. Ажлын албаны дотоод бүтцийн нэгжүүдийн гүйцэтгэх чиг үүрэг, салбар хариуцсан газруудын үйл ажиллагааны харилцан уялдаатай байдал, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтэд мониторинг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах;

10.1.4. Хорооны даргын өгсөн чиглэлийн дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг хийх, төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хангаж ажиллах, Хорооны даргад тайлагнах;

10.1.5. Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын байдал, батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавих, зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгах талаар зөвлөмж боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

10.1.6. Хорооны үйл ажиллагааны эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, зайлсхийх чиглэлээр баримтлах бодлого боловсруулах, Хорооны удирдлагыг мэдээллээр хангах;

10.1.7. Үйл ажиллагааны эрсдлийн зохистой удирдлагын хүрээнд хяналт, шалгалтын орчин үеийн зохистой арга хэрэгсэл, системийг судлах, өөрийн үйл ажиллагаандаа ашиглах, нэвтрүүлж хэрэгжилтийг хангах.

--- о О о ---